


# Гадаад Харилцагчдынхаа Анхааралд

Банкны харилцах данс нээлгэхэд дараах бичиг баримт зайлшгүй шаардлагатайг анхаарна уу. Шинкин банкинд данс нээлгэхээр ирэхдээ дурдсан зүйлсийг биедээ авч очоорой.

## 《 Банкны данс нээлгэхэд шаардлагатай бичиг баримтууд 》

### Биеийн байцаалт

#### Оршин суух үнэмлэх (Загвар)




Эх сурвалж: Японы Цагаачлалын Товчоо Цахим хуудас

- Биеийн байцаалт нь эзэмшигчийн фото зураг, эзэмшигчийн нэр, (Япон улс дахь) Хаяг болон төрсөн огноог зайлшгүй харуулсан байна.

- Жишээ нь:
- ▶ Оршин суух үнэмлэх
  - ▶ Байнгын оршин суугчийн тусгай гэрчилгээ
  - ▶ Хувийн дугаарын карт
  - ▶ Паспорт

\* Данс нээх явцад хүсэлт гаргагчийн Японд оршин суух хугацааг баталгаажуулж шалгах магадлалтай. Хүсэлт гаргагчаас нэгээс илүү биеийн байцаалт үзүүлэхийг шаардаж магадгүй.

### Дардас тамга



- Данс нээх үед, өргөдлийн маягт нь хүсэлт гаргагчийн дардас тамгаар хүчин төгөлдөр болно. Ихэнх санхүүгийн байгууллага гарын үсгийг хоёрдогч сонголт болгон зөвшөөрдөг болохыг анхаарна уу.
- Та дардсаа захиалах үедээ, банкны гүйлгээний шаардлагыг хангасан байх ёстойг дэлгүүрийнхэнд сануулаарай.

### Бусад шаардлагууд

- Банкны данс нээлгэхээр хандахдаа, ажлын үнэмлэх эсвэл хүсэлт гаргагчийн ажил эрхлэлтийн байдлыг тодорхойлох өөр бичиг баримт авч ирнэ үү.
- Данс нээх явцад хүсэлт гаргагчийн ажил эрхэлдэг газар луу утсаар холбогдож баталгаажуулах магадлалтайг анхаарна уу.
- Япон хэлний тусламж шаардлагатай хүсэлт гаргагч нь өөрийн ажлын хүрээллийн зэрэг өөр хүнээс туслалцаа хүсэх хэрэгтэй.
- Оюутан бол оюутны үнэмлэхээ авч очих шаардлагатай.
- Хууль тогтоомжид заасны дагуу банк, хүсэлт гаргагчийн оршин суугаа улсыг татварын зорилгоор шалгаж, мөн хүсэлт гаргагчид АНУ-ын албан татвар ногдуулах эсэхийг шалгаж болох бөгөөд хүсэлт гаргагчийн татвар төлөгчийн дугаарыг шаардаж болно.

\* Түүнчлэн санхүүгийн байгууллага тус бүрийн тогтоосон дүрэм журмыг сахин мөрдөнө үү.

Цалингийн дансаа тохируулах болон ашиглалтын зардлыг автоматаар төлөх тухай мэдээллийг лавлана уу.

## Харилцах дансыг худалдах эсвэл худалдан авах нь ял шийтгэл хүлээхүйц хэрэг зөрчил юм!

- Харилцах данс худалдах эсвэл худалдан авах (жишээ нь: харилцах дансны тооцооны дэвтэр эсвэл АТМ-ээс мөнгө авдаг бэлэн мөнгөний карт зарах эсвэл авах) нь Япон улсын хуулиар хориотой бөгөөд худалдагч болон худалдан авагч хоёул шийтгэл хүлээнэ.
- Хэрвээ та оршин суух хугацаа дууссан гэх мэт шалтгаанаар эх орон руугаа буцахаар болсон бол банкны дансыг хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх үүднээс дансаа хаалгаарай.

